



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв  
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.08.02 № 01/1470

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ  
ЭТГЭЭДҮҮДЭД**

**Тодруулга хүргүүлэх тухай**

Тус компаниас зарласан ЭТТХК/20240102505 дугаартай “Шинээр нийлүүлэгдэх XCMG маркийн техникийн сэлбэг” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг тендерт оролцохыг сонирхогч этгээдээс гаргасны дагуу Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь заалтын дагуу хянаж, 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн №01/1326 тоот “Тендерийн баримт бичиг хянасан тухай” албан бичиг ирүүлсний дагуу багцлах боломжгүй байна.

Учир нь шинээр нийлүүлэгдсэн XCMG маркийн хүнд машин механизмуудын үйлдвэрийн баталгаат хугацаа дуусаагүй бөгөөд үйлдвэрлэгчийн баталгаат техник үйлчилгээний материал, сэлбэг эд ангийг нийлүүлээгүйгээс үүсэх томоохон эвдрэл, гэмтлээс гадна үндсэн техник зогссоноор компанийн хэвийн үйл ажиллагаа алдагдах эрсдэлтэй байгаа тул энэ тухай тайлбараа Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт хүргүүлсэн ба мөн тендерт оролцохыг сонирхогч этгээдүүдэд мэдэгдэж байна.

Мөн тус тендерт оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга ирүүлснийг доорх тайлбараар хүргүүлж байна. Үүнд:

Д/д	Тодруулгын асуулт	Тодруулгын хариулт
1	ТШЗ 2.1-д нийт төсөвт өртөг 15,371,682,000 төгрөг Үүнд: Багц 1- 641,485,000 төгрөг Багц 2 - 2,274,905,000 төгрөг Багц 3 - 443,843,000 төгрөг Нийт 3,360,233,000 төгрөг болж байна. Иймд аль төсөвт өртөг нь зөв бэ? 15,371,682,000 төгрөг 3,360,233,000 төгрөг	Дээрх тендер шалгаруулалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь заалтын дагуу багцалсан ба 5 багцын батлагдсан төсөвт өртөг нийт 15,371,682,000 төгрөг бол зарлагдсан 3 багцын батлагдсан төсөвт өртөг нь - Багц 1- 641,485,000 төгрөг - Багц 2- 2,274,905,000 төгрөг - Багц 3- 443,843,000 төгрөг байна.
2	Тендер нээх эцсийн хугацаа хойшлох уу?	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 09 цаг 00 минут Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.

	Огноо: 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Цаг: 09 цаг 30 минут
--	---

Дээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ